

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/29/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТ

Зуунмод 2022 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Албан шаардлага	19
4.3 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/192
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
Д.БАТЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 оны/сарын/дүгнэлт
19020594

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	999,345,211.78	1,044,788,616.46
33	АВЛАГА	73,541,983.78	118,354,888.46
335	Бусад авлага	73,541,983.78	118,354,888.46
35	БАРАА МАТЕРИАЛ	925,803,228.00	926,433,728.00
351	Түүхий эд материал	-	88,800.00
354	Хангамжийн материал	925,803,228.00	926,344,928.00
35410	Бичиг хэргийн материал	190,000.00	300,000.00
35420	Аж ахуйн материал	3,651,179.00	3,651,179.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,160,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,301,000.00	-
35450	Барилгын засварын материал	-	74,800.00
35470	Бусад хангамжийн материал	920,661,049.00	921,158,949.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	845,488,128.73	825,387,353.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	845,488,128.73	825,387,353.92
392	Биет хөрөнгө	824,445,128.73	804,447,020.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	777,147,193.00	777,147,193.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,704,287.06)	(40,032,993.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	88,985,000.00	88,985,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,699,999.77)	(35,444,895.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,837,094.00	17,167,094.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,126,495.35)	(5,774,257.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,099,403.20	12,274,303.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,092,779.29)	(9,874,423.92)
393	Биет бус хөрөнгө	21,043,000.00	20,940,333.28
39301	Програм хангамж	308,000.00	308,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(102,666.72)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,735,000.00	20,735,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,844,833,340.51	1,870,175,970.38
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	73,466,380.35	118,124,380.35
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	73,466,380.35	118,124,380.35
413	Өглөг	73,466,380.35	118,124,380.35
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	73,466,380.35	118,124,380.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,771,366,960.16	1,752,051,590.03
51	Засгийн газрын хувь оролцоо	1,771,366,960.16	1,752,051,590.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,735,000.00	20,735,000.00
51101	Өмч: - төрийн	20,735,000.00	20,735,000.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	(19,315,370.13)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	47,733,304.20	47,733,304.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,844,833,340.51	1,870,175,970.38

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	755,040,934.00	238,204,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	515,985,134.00	50,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	515,985,134.00	50,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	515,985,134.00	50,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	142,634.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	515,842,500.00	50,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	239,055,800.00	238,154,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,490,000.00	7,865,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,490,000.00	7,865,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	226,565,800.00	230,289,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	226,565,800.00	230,289,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	246,202,733.34	257,469,970.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	246,202,733.34	257,469,970.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	234,685,023.59	254,238,231.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	149,740,796.03	153,582,767.00
210101	Үндсэн цалин	127,477,010.03	122,479,116.00
210102	Нэмэгдэл	17,830,186.00	25,550,951.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,433,600.00	5,552,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,828,925.29	20,270,720.67
210201	Тэтгэврийн даатгал	18,828,925.29	14,626,538.67
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,458,774.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,156,579.29
210204	Ажилгүйдлийн даатгал	-	275,184.39
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,753,644.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,356,654.00	30,572,388.90
210301	Гэрэл, цахилгаан	5,547,538.00	5,459,281.00
210302	Түлш, халаалт	22,877,796.00	24,183,168.90
210303	Цэвэр, бохир ус	931,320.00	929,939.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,129,523.50	10,545,200.00
210401	Бичиг хэрэг	2,394,595.00	1,852,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,332,200.00	6,085,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,402,728.50	2,607,500.00
2105	Нормативт зардал	-	85,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	85,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	196,935.00	3,631,440.00
210604	Урсгал засвар	196,935.00	3,631,440.00
2107	Томилолт, зочны зардал	900,000.00	6,677,100.00
210702	Дотоод албан томилолт	900,000.00	6,677,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	959,065.00	934,440.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	164,000.00	136,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,665.00	165,740.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,500.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	394,900.00	360,000.00

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,573,124.77	27,938,774.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,059,244.00	3,715,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	964,450.00	617,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,549,430.77	23,605,674.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,517,709.75	3,231,738.75
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,517,709.75	3,231,738.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,517,709.75	3,231,738.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	508,838,200.66	(19,265,370.13)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	50,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	50,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(50,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	508,838,200.66	(19,315,370.13)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	239,198,434.00	238,154,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	142,634.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	142,634.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	142,634.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	142,634.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	239,055,800.00	238,154,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,490,000.00	7,865,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	12,490,000.00	7,865,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	226,565,800.00	230,289,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	226,565,800.00	230,289,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	232,903,934.00	234,649,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	232,903,934.00	234,649,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	221,386,224.25	231,417,961.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	152,778,990.03	153,717,238.00
210101	Үндсэн цалин	127,362,642.03	122,613,587.00
210102	Нэмэгдэл	20,330,748.00	25,550,951.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,085,600.00	5,552,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,781,862.72	20,291,154.35
210201	Тэтгэврийн даатгал	17,277,440.57	14,196,781.33
210202	Тэтгэмжийн даатгал	404,803.61	1,579,927.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	323,842.90	1,253,501.78
210204	Ажилгүйдлийн даатгал	70,525.05	296,285.79
210205	Эрүүл мэндийн даатгал	705,250.59	2,964,658.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,218,937.00	30,572,388.90
210301	Гэрэл, цахилгаан	5,409,821.00	5,459,281.00
210302	Түлш, халаалт	22,877,796.00	24,183,168.90
210303	Цэвэр, бохир ус	931,320.00	929,939.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,075,235.50	9,354,200.00
210401	Бичиг хэрэг	2,300,330.00	1,962,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,633,200.00	4,784,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,141,705.50	2,607,500.00
2105	Нормативт зардал	700,000.00	583,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	583,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	513,985.00	4,866,240.00
210604	Урсгал засвар	513,985.00	4,866,240.00
2107	Томилолт, зочны зардал	900,000.00	6,765,900.00
210702	Дотоод албан томилолт	900,000.00	6,765,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	983,065.00	934,440.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	164,000.00	136,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	89,665.00	165,740.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,500.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	394,900.00	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,434,149.00	4,333,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,354,754.00	3,715,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,079,395.00	617,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,517,709.75	3,231,738.75
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	11,517,709.75	3,231,738.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,517,709.75	3,231,738.75

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,294,500.00	3,504,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,294,500.00	3,504,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,294,500.00	3,504,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,294,500.00	3,504,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,294,500.00	3,504,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	(6,294,500.00)	(3,504,900.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	966,722,341.68	966,722,341.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	966,722,341.68	966,722,341.68
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,702,898,655.96	1,771,366,960.16
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,702,898,655.96	1,771,366,960.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,702,898,655.96	1,771,366,960.16
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-19,315,370.13	-19,315,370.13
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,683,583,285.83	1,752,051,590.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	230,289,100.00	227,702,361.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	230,289,100.00	227,702,361.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	230,289,100.00	227,702,361.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,806,200.00	153,717,238.00
210101	Үндсэн цалин	116,334,600.00	122,613,587.00
210102	Нэмэгдэл	31,591,600.00	25,550,951.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,880,000.00	5,552,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,763,800.00	20,291,154.35
210201	Тэтгэврийн даатгал	14,611,600.00	14,196,781.33
210202	Тэтгэмжийн даатгал	1,538,100.00	1,579,927.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,230,400.00	1,253,501.78
210204	Ажилгүйдлийн даатгал	307,600.00	296,285.79
210205	Эрүүл мэндийн даатгал	3,076,100.00	2,964,658.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,709,700.00	30,572,388.90
210301	Гэрэл, цахилгаан	5,247,000.00	5,459,281.00
210302	Түлш, халаалт	22,702,700.00	24,183,168.90
210303	Цэвэр, бохир ус	2,760,000.00	929,939.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,354,200.00	9,354,200.00
210401	Бичиг хэрэг	1,962,500.00	1,962,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,784,200.00	4,784,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,607,500.00	2,607,500.00
2105	Нормативт зардал	583,300.00	583,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	583,300.00	583,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,866,700.00	4,866,240.00
210604	Урсгал засвар	4,866,700.00	4,866,240.00
2107	Томилолт, зочны зардал	8,524,300.00	6,765,900.00
210702	Дотоод албан томилолт	8,524,300.00	6,765,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,063,400.00	934,440.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	136,700.00	136,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	166,700.00	165,740.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	617,500.00	617,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	617,500.00	617,500.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	230,289,100.00	230,289,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	230,289,100.00	230,289,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	230,289,100.00	230,289,100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	15.00	15.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	7,220,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,934,540.00	7,220,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,934,540.00	7,220,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,934,540.00	7,220,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,934,540.00	7,220,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,750,000.00	7,865,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,750,000.00	7,865,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хү	8,750,000.00	7,865,500.00
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг хуулиар зохицуулах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль бусад хууль тогтоомжид заасан холбогдох чиг үүргийг орон нутагт хариуцан гүйцэтгэж ИТХ, Засаг даргад эрхлэх асуудлын хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, төсвийн хөрөнгө болон орон нутгийн өмч хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж, худалдан авах ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг хуулийн дагуу зохицуулах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах харилцааг зохицуулах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах,
- төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах;
- Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах;
- Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2016 оны 12 дугаар сарын 08-ны 18 дугаар тушаалаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг, 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/05 тушаалаар дотоод хяналт шалгалтын зөвлөлийг 3 ажилтны бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан. Дотоод хяналтын ажлын хэсгийн мөрдөж ажиллах журам, заавар боловсруулж 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тушаалаар баталсан байна.

Орон нутгийн өмчийн газрын дотоод хяналтын ажлын хэсэг нь 2021 оны жилийн ажлын төлөвлөгөөнд сахилга хариуцлага, санхүүгийн үйл ажиллагааны талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тусган батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж ажилласан байна.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 755,040.9 мянган төгрөгийн 1,5 хувиар буюу 11,325.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,494.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 238,204.6 мянган төгрөгийн 1,5 хувиар буюу 3,573.1 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,679.8 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 7,752.5 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд орон нутгийн төсвөөс 230,289.1 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан. Нэмэлт санхүүжилтийн дансанд цахим тендер худалдан авах ажиллагааны орлого 7,865,5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 231,573.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд үйл ажиллагааны орлогоос нийт 3,504.9 мянган төгрөгийн иж бүрэн компьютер 1 ширхэг 3,330.0 мянган төгрөг, сандал 1 ширхэг 174.9 мянган төгрөгөөр тус тус худалдан авч тайлагнасан байна.

Бараа материалын дансанд ОБГ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн 50.0 мянган төгрөгийн амны хаалтыг бараа материалыг орлогоор бүртгэсэн байна. Нийт 18,229.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авч, 17,599.1 мянган төгрөгийн бараа материалыг зарлагдсан байна.

Авлага, өглөгийн талаар:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар цалингийн авлага 20.0 мянган төгрөг, ХХОАТ-ын авлага 28.3 мянган төгрөг, НДШ-ийн авлага 182.2 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 118,124.4 мянган төгрөг нийт 118,354.9.9 мянган төгрөгийн авлага, 118,124.4 мянган төгрөгийн өглөгийн тус тус үлдэгдэлтэй тайлагнагдсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар авлага данс 73,696.9 мянган төгрөг, бараа материал 926,433.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 825,387.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	73,541.98	118,354.89	44,812.90
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	925,803.23	926,433.73	630.50
Үндсэн хөрөнгө	845,488.13	825,387.35	(20,100.77)
Нийт хөрөнгө	1,844,833.34	1,870,175.97	25,342.63
Өр төлбөр	73,466.38	118,124.38	44,658.00
Засгийн газрын оролцоо	1,771,366.96	1,752,051.59	(19,315.37)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,844,833.34	1,870,175.97	25,342.63

Авлагын дансны үлдэгдэл нь Тэтгэвэрт гарсан ажилтны цалин хөлсийг давхар бодож олгосноос үүссэн 230.5 мянган төгрөг, түрээсийн орон сууцтай холбогдолтой хувь хүмүүсээс авах авлага 73,466.4 мянган төгрөг байна. Бараа материалын дансны үлдэгдэл 926,433.7 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 630.5 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал 497.9 мянган төгрөгөөр, эм боох материалын үлдэгдэл 88.8 мянган төгрөгөөр, засварын материал 74.8 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 1,160.0 мянган төгрөгөөр, бичиг хэргийн материалын үлдэгдэл 110.0 мянган төгрөгөөр өсөж түлш шатах тослох материалын эхний үлдэгдэл 1,301.0 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын үлдэгдэл өсөхөд шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 825,387.4 мянган төгрөг болж 3,504.9 мянган төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааны орлогоос 3,504.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 239,500.6 мянган төгрөгөөр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 9,211.5 мянган төгрөгөөр бууруулан 230,289.1 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь байр ашиглалттай холбоотой зардал, хангамжийн зардал, нормативд зардал хасагдсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 230,289.1 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого 7,865.5 мянган төгрөгийн орлого орж үндсэн үйл ажиллагаанд 234,922.9 мянган төгрөг зарцуулж 3,231.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд цахим тендерийн хураамж, дуудлага худалдааны орлого 7,865.0 мянган төгрөг орж дуудлага худалдаатай холбоотой бичиг хэрэг, зар мэдээ, компьютер худалдан авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд түрээсийн орон сууцны түрээсийн орлогыг бүртгэх НББ-ийн орчин, эрх зүйн үндсийг бүрдүүлээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Авлагын журналд ажиллагсадаас авах авлагын эхний үлдэгдэл, цалингийн урьдчилгаа дансны эхний болон эцсийн үлдэгдэл 1,599.87 мянган төгрөгийг хасах дүнтэй тайлагнасан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж, бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн №28 тоот албан бичгээр ирүүлж зөрчлийг таслан зогсоосон байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц түрээсийн орон сууцны түрээсийн орлогыг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,386.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6,946.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 400.0 мянган төгрөгийн албан шаардлага, худалдан авалтыг татварын цахим баримтаар баталгаажуулаагүй 5,039.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

4.1.1 Авлагын журналд ажиллагсдаас авах авлагын эхний үлдэгдэл, цалингийн урьдчилгаа дансны эхний болон эцсийн үлдэгдэл 1,599.87 мянган төгрөгийг хасах дүнтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх.” гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн.

4.1.2 Зарцуулагдаагүй үлдэгдэл 3,231.7 мянган төгрөгийг төвлөрүүлэхдээ мөнгөн гүйлгээний тайлан, мөнгөн гүйлгээний журналд өөр өөр дансанд бичилт хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх.” гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн.

4.1.3 Тэнгэрлэг хад ХХК-ас авсан 390.0 мянган төгрөгийн шатахууныг Магнай трейд ХХК авсан шатахуун гэж бүртгэсэн, 1,725.0 мянган төгрөгийн томилолтын урьдчилгааг өглөг дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн

5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх." гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн.

4.2 Албан шаардлага

4.2.1 Ач есөн энх ХХК-ас 2021 оны 11 сард машины тоноглол болох нэмэлт гэрэл 400.0 мянган төгрөгөөр худалдаж авсан, батлагдсан төсвийн 10-аас доошгүй хувийг хэмнэж ажиллаагүй байна. Энэ нь МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах хэмжээний талаар”-ын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Татварын цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай хийсэн 5,039.9 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт бүрийг татварын цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс					
				Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Орон нутгийн өмчийн газар	6	12,386.5	4	6,946.6	1	400.0	1	5,039.9